10	Зөгийн амьдрах орчин, эрүүл ахуйн зохистой нөхцөлийг хангуулах чиглэлээр зөгийн аж ахуйтай хамтран ажиллах	Зөгийн амьдрах орчин, эрүүл ахуйн менежмент	10.1 Зөгийн суурийн эрүүл ахуйн менежмент	+	30		+	+			Зөгийн суурь байрлуулах газрын аюулгүй байдлын тухай	Зөгийн суурийн, бүлийн, бэлчээрийн эрүүл ахуйн шаардлагыг хангах талаар зөгийчдөд мэдээлэл хүргэх, зөвлөх
			10.2 Зөгийн бүлийн эрүүл ахуйн менежмент	+		+	+	+			Зөгийн бүлийн дотоод орчинд бий болох эрсдэл, түүнээс сэргийлэх тухай	
			10.3 Зөгийн бэлчээрийн эрүүл ахуйн менежмент	+			+	+			Пестицид бодисын эрсдэлийн тухай	
11	Зөгийн өвчин, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх	Зөгийн өвчин, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ	11.1 Өвчин үүсэх хүчин зүйл, тархах зам	+	120		+	+	+	+	Өвчний ангилал, өвчин үүсэх хүчин зүйл, тархах замын тухай	Америк үжил, Европ үжил, Варрооз, Аскосфероз зэрэг болон бусад өвчний үед сорьц авах, оношлох, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх
			11.2 Америк үжил, Европ үжил өвчин, тэдгээрийг оношлох, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ	+		+	+	+	+	+	Америк үжил, Европ үжил өвчин, тэдгээрийг оношлох, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ. Эмгэгт материалын дээж авах, хадгалах, илгээх тухай	
			11.3 Варрооз, түүнийг оношлох, халдварлалтын түвшин тогтоох, урьдчилан сэргийлэх ба тэмцэх арга хэмжээ	+		+	+	+	+	+	Варрооз, түүнийг оношлох, халдварлалтын түвшин тогтоох, урьдчилан сэргийлэх ба тэмцэх арга хэмжээ. Эмийн бус аргаар тэмцэх (хачгийн занга бэлтгэх) аргын тухай	
			11.4 Аскосфероз өвчнийг оношлох, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ	+		+	+	+	+	+	Аскосфероз өвчнийг оношлох, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ. Эмгэгт материалын дээж авах, хадгалах, илгээх тухай.	
			11.5 Зөгийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх бусад хүчин зүйл, урьдчилан сэргийлэх	+			+	+	+	+	Зөгийн хордлого, мэрэгч болон бусад амьтдын хөнөөлийн тухай	
12	Эмийн хэрэглээнд зааварчилгаа өгөх, хяналт тавих	Эмийн зохистой хэрэглээ	12.1 Эмийн хэрэглээ, анхаарах зүйлс	+	15	+	+	+	+	+	Эм, бэлдмэл тэдгээрийг хэрэглэх арга, үр дүнг тооцох тухай	Эмийн зохистой хэрэглээний талаар зөгийчдөд зөвлөгөө өгөх
13	Зөгий өвөлжүүлэх байрны эрүүл ахуйг хангуулах чиглэлээр зөгийн аж ахуйтай хамтран ажиллах	Зөгий өвөлжүүлэх байрны эрүүл ахуйн менежмент	13.1 Өвөлжөөний байрыг халдваргүйтгэх	+	45	+	+	+	+	+	Мөөгөнцөрийн эсрэг заалттай эм бэлдмэлийг ашиглах тухай	Зөгийн өвөлжөөний байрыг халдваргйтгэх Зөгий өвөлжих эрүүл ахуйн нөхцөлийг хангах тухай зөгийчдөд зөвлөгөө өгөх
			13.2 Зөгий өвөлжих эрүүл ахуйн нөхцөлийг хангах	+			+	+			Температур, чийгшил, агаарын урсгалыг тохируулж болохуйц өвөлжих байр бэлтгэх тухай	
14	Зөгийн эрүүл мэнд, эрүүл ахуйн бүртгэлд зөвлөх, хяналт тавих, ашиглах, мэдээлэх	Зөгийн эрүүл мэнд, эрүүл ахуйн бүртгэл, түүнийг хөтлөх	14.1 Бүртгэлийн зорилго, ач холбогдол, агуулга	+	45		+	+	+	+	Зөгийн эрүүл мэнд, эрүүл ахуйн бүртгэлийн тухай	Зөгийн эрүүл мэнд, эрүүл ахуйн бүртгэл хөтлөлтөнд зөвлөх, хяналт тавих, мэдээллийг ашиглах, бүртгэх, мэдээлэх
			14.2 Бүртгэлийн дэвтэрийг хөтлөх, мэдээлэх	+		+	+	+	+	+		
15	Зөгийн аж ахуйд үзүүлэх үйлчилгээний бизнесийн үр ашгийг төлөвлөх, тооцох	Зөгийн аж ахуйд үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээний бизнесийг төлөвлөх, үр ашгийг тооцох	15.1 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс зөгийн аж ахуйд үзүүлэх үйлчилгээнийний төрлүүд болон үр ашиг	+	60		+	+			Зөгийн аж ахуйд үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээний бизнесийг төлөвлөх, үр ашгийг тооцох тухай	Зөгийн аж ахуйд үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээний бизнесийг төлөвлөх, үр ашгийг тооцох

Тайлбар: "Тийм" гэсэн тохиолдолд (+) тэмдэглэгээг хийв.

Хавсралт 7. Зөгийн гэрийн (үүр хайрцаг) ажлын зураг

Зөгийн гэрийн их бие :



Зөгийн гэрийн стандарт /MNS 6829 : 2020/ -ийг жишиг болгон ашиглав.

Их биеийн хажуу хэсэг:



Их биеийн нүүр болон арын хэсэг:z



Зөгийн гэрийн стандарт /MNS 6829 : 2020/ -ийг жишиг болгон ашиглав.

Зөгийн гэрийн ул мод (суурь)

Ул модны шалны хэсэг:



Ул модны нүүр хэсэг:



Зөгийн гэрийн стандарт /MNS 6829 : 2020/ -ийг жишиг болгон

Ул модны нисгэвчний гадна хэсэг:



Ул модны хажуу хэсэг:



Ул модны арын хэсэг:



Зөгийн гэрийн стандарт /MNS 6829 : 2020/ -ийг жишиг болгон ашиглав.

Зөгийн гэрийн хүзүүвч

Хүзүүвчний хэсгүүд:



Зөгийн гэрийн стандарт /MNS 6829 : 2020/ -ийг жишиг болгон ашиглав.

Зөгийн гэрийн таг



Тагны нүүр, ар, хажуу хэсгүүд:



Тагны тавцан хэсэг:



Зөгийн гэрийн стандарт /MNS 6829 : 2020/ -ийг жишиг болгон ашиглав.

Зөгийн гэрийн жааз

Жаазны гуя мод:



Жаазны дээд хөндлөвч:



Жаазны доод хөндлөвч:



Зөгийн гэрийн стандарт /MNS 6829 : 2020/ -ийг жишиг болгон ашиглав.

Зөгийн гэрийн бусад хэрэгсэл

Хашлага самбар:



Зөгийн тэжээлийн идүүр:



Зөгий зайлуулагч самбар:

Зөгийн гэрийн стандарт /MNS 6829 : 2020/ -ийг жишиг болгон

Хавсралт 8. Бүлэнцэрийн гэрийн ажлын зураг

Хээлтүүлгийн хайрцаг:



Хээлтүүлгийн гэрийн их бие:



Хээлтүүлгийн гэрийг төслийн багаас зөгийчидтэй хамтран бүтээв.

Хээлтүүлгийн гэрийн ул мод:



Хээлтүүлгийн гэрийн таг:



Хээлтүүлгийн гэрийг төслийн багаас зөгийчидтэй

Хээлтүүлгийн гэрийн хүзүүвч:



Хээлтүүлгийн гэрийн жааз



Хээлтүүлгийн гэрийг төслийн багаас зөгийчидтэй хамтран бүтээв.

Эх зөгийтэй өвөлжих бүлэнцэрийн гэрийн ажлын зураг:



Бүлэнцэрийн гэрийн жааз:



Бүлэнцэрийн гэрийн их бие:



Бүлэнцэрийн гэрийн үл мод:



Эх зөгийтэй өвөлжих бүлэнцэрийн гэрийг төслийн багаас зөгийчидтэй хамтран бүтээв.

Бүлэнцэрийн гэрийн таг:



Бүлэнцэрийн гэрийн хүзүүвч:



Эх зөгийтэй өвөлжих бүлэнцэрийн гэрийг төслийн багаас зөгийчидтэй хамтран бүтээв.

Бүлэнцэрийн гэрийн хашлага самбар:



Бүлэнцэрийн гэрийн тэжээлийн идүүр:



Эх зөгийтэй өвөлжих бүлэнцэрийн гэрийг төслийн багаас зөгийчидтэй хамтран бүтээв.

Хавсралт 9.

Зөгийн аж ахуйн нэр томьёоны англи-монгол тайлбар толь бичиг (A-W)[23]

	English Mongolia	Discriotion Тайлбар
A		
1	Abdomen **Хэвлий**	Зөгийн биеийн 3-р хэсэг. Ажилчин зөгийний биеийн энэ хэсэгт лавны булчирхай гадагш нээгдсэн байдаг ба амтат шүүс нөөцлөх ходоод, хоол боловсруулах замын эрхтнүүд, хорны булчирхай, хатгуур, ялгадасны сүв зэрэг байралдаг.
2	Absconding **Дайжих**	Таагүй нөлөөний улмаас зөгийн бүл бүхэлдээ үүрээ орхиж явах
3	Acarapis woodi **Акарин хачиг**	Бие гүйцсэн зөгийн гуурсан хоолойд цус сорон шимэгчилдэг хачгийн шинжлэх ухааны оноосон нэр юм. Тус хачиг хор уршгаар бага ч зөгийн амьдрах хугацааг богиносгож байна гэж үздэг. Мөн цус сорох үедээ вирус дамжуулагч болж байдаг.
4	Adulterated honey **Хуурамч зөгийн бал**	"Зөгийн бал" "Цэвэр зөгийн бал" гэж танилцуулагдаж байгаа боловч зөгийн балны бус зүйл найрлаганд нь багтсан бөгөөд энэ тухайг шошгонд тэмдэглэгдээгүй бүтээгдэхүүн юм.
5	After swarm **Хоёрдогч зөгий**	Хуучин эх зөгий сүрэглэсний дараа удалгүй хээлгүй эх зөгий сүрэглэх явдал
6	Africanized honey bee **Африкжсан зөгий**	Бразилд туршигдаж байсан Африкийн уугуул зөгий ***Apis mellifera*** ***scutellata*** нь сүрэглэж зугтаад өөр бусад зөгийтэй үржилд орж шинээр бий болсон ба үржилд орохдоо амархан шинж чанартай зөгий юм. Америк тивд өргөн тархсан байна.
7	Alarm pheromone **Түгшүүрийн фермон**	Ажилчин зөгийн хатгуурын дэргэд байрлах булчирхайнаас ялгардаг үнэрт бодис ба энэ нь бүлийхээ бусад зөгийд сэрэмжлүүлэх дохио болдог.
8	Alighting board **Нислэгээс буух хавтан**	Нислэгээс ирж буй зөгий нисгэвчний өмнө буух талбай юм. **landing board** гэж лавлана уу.

[23] Эх сурвалж: JAICAF. 2009. 開発途上国での養蜂振興と実務 - アフリカを事例として -. (JAICAF "Хөгжиж буй орнуудын зөгийн аж ахуйг хөгжүүлэх, дадлагажуулах нь - Африкийн жишээн дээр -")

9	American foulbrood **Америк үжил өвчин**	Америк үжил өвчин нь Paenibacillus гэх спор (хуяг) үүсгэгч бактераар үүсдэг үрвэлдэйн халдварт өвчин юм. Авгалдайн хөгжлийн 1-2-р шатанд халдварлаж өвчлөл хүүхэлдэйд илэрдэг (ташаалавч хаагдаснаас хойш үхдэг). Үрвэлдэй үхэж эхлэхэд ташаалавчны хаалт эвдэрч хонхойх ба түүний дараа ажлын зөгий жижиг нүх гаргадаг. Энэ үед үхсэн үрвэлдэй бүхий хэсэгрүү шүдэнзний мод зэргийг шургуулааад авахад маш наалдамхай утаслаг гарч ирдэг. (европ үжил өвчний үед ийм утаслаг байхгүй). Эцэст нь ташаалавчны хаалт эвдэрч онгойх ба үхсэн үрвэлдэй хатсан байдалтай ташаалавчны доод талд үлдсэн байдаг. Үрвэлдэй халдварлаж үхэж эхлэхэд өмхий үнэртэй болдог учраас зөгийн хайрцгны тагийг нээх үед маш өмхий үнэр үнэртсэн тохиолдолд энэ өвчин халдварласан байж болзошгүй гэж үзнэ. Спор үүсгэгчийн хувьд антибиотик эмчилгээ үр дүнгүй бөгөөд эмийн хэрэглээ нь эсрэгээрээ өвчин ил харагдахгүй болж маш өргөн хэмжээний халдвар дэгдээх эрсдэлтэй.
10	Anaphylactic shock **Анапилаксийн шок**	Зөгийн хор, хоол хүнс, эмийн бодис зэргээс үүдэлтэй хүний биед илрэх харшлын цочмог урвал юм. Арьс туурах, улайх, хавагнах зарим тохиолдолд амьсгалын зам бачуурах, толгой эргэх, даралт буух, ухаан алдах зэрэг шинж тэмдэг илэрч болдог. Биеийн шингэний эргэлтийн хэвийн байдал алдагдаж биед цочрол үүсдэг. Энэ нь хүний амь насанд аюул учруулж болзошгүй юм.
11	Apiary (pl.-ies) **Зөгийн маллаж буй газар**	Зөгийг арчлан маллах зорилгоор зөгийн бүл, нөөц үүр хайрцаг, бусад шаардлагатай эд зүйлс зэргийг байршуулсан газар
12	Apiculture **Зөгийн аж ахуй**	Балт зөгийг маллах, тэжээх технологи болон шинжлэх ухааны цогц ойлголт юм.
13	Apis mellifera **Апис мэлфэра**	Гэршүүлсэн балт зөгий нь Европоос гаралтай бөгөөд одоогоор дэлхий нийтээр зөгийн аж ахуйд үржүүлж байна. Балт зөгийн түгээмэл ашиглагддаг үүлдрүүдэд A. m. ligustica (Итали), A. m. caucasia (Кавказ), A. m. carnica (Карника), A. m. mellifera (Германны хар зөгий) зэрэг багтдаг. Африк зөгий нь биологийн ангилалын хувьд дэд зүйлд багтдаг ба A. m. scutellata болон A. m. capensis нэлээдгүй тархсан байдаг.
14	Artificial swarm **Бүл салгах**	Үржлийн улиралд шинэ эх зөгий төрөхийг хүлээлгүйгээр үндсэн бүлээс шинээр торниж буй ажлын зөгийн нялх авгалдай бүхий жаазыг салгах байдлаар бүлийг хуваах арга юм. Зөгийг үржүүлэх үндсэн арга болдог билээ. Мөн сүрэглэлээс сэргийлэх аргын нэг болдог нь чухал ач холбогдолтой байдаг.

B		
15	Balling	Ажилчин зөгийнүүд өөрийн бүлийн биш гэж үзсэн эх зөгийг хэсэг бүлгээрээ нийлж хатгах, хөл, далавчнаас чангаах зэргээр түүнийг устгахаар завдаж буй бөөгнөрөл
16	Bee bread **Зөгийн талх**	Зөгий цуглуулж авчирсан цэцгийн тоосоо балтайгаа хольж сархиагтаа нөөцөлсөн зүйл
17	Bee brush **Зөгийн шүүр**	Зөгийг жааз болон бусад зүйл дээрээс шүүрдэж зайлуулдаг зөөлөн үстэй сойз мэт зүйл
18	Bee space **Зөгийд шаардлагатай зай**	Зөгий сархиагаа барихдаа тохируулсан сархиаг хоорондын зай (үндсэндээ зөгий зорчих зай) юм. Иймээс жааз хийхдээ энэ хэмжээ, зайг харгалзах шаардлагатай байдаг.
19	Bee suit **Зөгийчний өмсгөл**	Ажиллаж байх үед зөгийд хатгуулах, хир толбо болохоос сэргийлэх зорилгоор зөгийчин хүний өмсдөг хувцас юм. Ихэвчлэн цагаан өнгөтэй, мөн малгай цамц нь үргэлж хийцтэй байх нь элбэг байдаг.
20	Bee veil **Толгойн торон малгай**	Хүзүү толгойг зөгийд хатгуулахаас хамгаалсан нарийн ширхэгтэй торон малгай. Хамгаалах хэрэгсэл юм.
21	Bee venom **Зөгийн хор**	Зөгий хатгах үед түүний хорны булчирхайнаас ялгарсан шингэн. Зөгийн аж ахуйн нэгэн төрлийн бүтээгдэхүүн болдог.
22	Beeswax **Зөгийн лав**	1.Ажилчин зөгийн хэвлийн хэсгийн 4 хос лавны булчирхайнаас ялгардаг лав. Үүнийг материал болгон ашиглаж сархиагаа барьдаг. 2. Зөгийн сархиагыг хайлуулж бэлтгэсэн лавыг төрөл бүрийн бүтээгдэхүүний орц болгон ашигладаг.
23	Bottom board **Доод хавтан**	Зөгийн үүр хайрцагны доод хэсэгт ул модон дээр давхар байралдаг хавтан. Сугалж авч цэвэрлэх зэрэг зориулалттай.
24	Brace comb **Бэхэлгээний сархиаг**	Хоёр сархиагны дээд хэсгийг хооронд нь бэхлэх, мөн үүр хайрцагны таг хэсгийг сархиагтай бэхлэх зорилгоор зөгий лаваараа барьж буй сархиагны хэсгүүд. Үүнийг бас **Buff comb** гэж нэрлэх нь бий.
25	Braula coeca **Зөгийн браулёз (бөөс)**	Зөгийн биед шимэгчилдэг далавчгүй шавж юм. (Хуучин сурах бичиг болгонд бичигдсэн байдаг). Англи нэр нь **Bee louse**.
26	Brood **Үрвэлдэй**	Ташаалавч (хонуур)-д бойжиж буй зөгийн өндөг, авгалдай, хүүхэлдэйний ерөнхий нэр.

27	Brood chamber **Үрвэлдэй бойжих хэсэг**	Зөгийн давхарласан үүр хайрцагны доод хэсэг буюу эх зөгий өндөглөх үрвэлдэй бойжих хэсэг юм. Энэ хэсэг нь 1-2 -р давхарт байдаг. Бал цуглуулах хэсэг **Honey chamber** -ийн эсрэг тал гэсэн үг юм.
C		
28	Candy **Кэнди**	Нунтаг элсэн чихрийг задарсан бүтэцтэй сахарын (инвертийн сахар) уусмалаар зуурч хатууруулсан зүйл. Зөгийн биед наалдахгүй тул тэжээлийн зорилгоор хээлтүүлгийн хайрцаг, эх зөгий хадгалах тор, өвөлжих зөгийн нэмэлт тэжээл зэрэгт ашиглана.
29	Capping **Балны хаалт**	Боловсорч гүйцсэн зөгийн бал бүхий ташаалавчны нимгэн лаван таглаа.
30	Caste **Каст**	Зөгийн бүл нь эх зөгий (хатанз), эр зөгий, ажилчин зөгий гэсэн 3-н төрлийн зөгийнөөс бүрддэг ба эдгээрийг ийнхүү нэрлэнэ.
31	Cell **Ташаалавч (хонуур)**	Зөгийн сархиагны нэгж хэсэг болох зургаан талт хэлбэр бүхий тасалгаанууд бөгөөд ажилчин зөгий болоод эр зөгийнх гэж байдаг. Эх зөгий бойжих тасалгааг эх зөгийн өлгийвч гэж нэрлэнэ.
32	Chalkbrood **Шохойжих өвчин**	Арчилгаа маллагааны таагүй нөхцөл бий болсноос буюу зөгийн үүр хайрцганд 30 хэмээс доош температур бий болоход нялх үрвэлдэйнүүд үхэж тэдгээр дээр **Ascosphaera apis** мөөгөнцөрийн утаслагууд үржиж улмаар цайвар өнгийн шохойжсон биет бий болдог. Цаашдаа муми хэлбэртэй масс болж хувирдаг. Энэ өвчнөөс хэр түргэн ангижирах нь арчилгааны нөхцөл, цэвэрлэгээ, халдваргүйтгэл зэргээс хамаарана.
33	Cluster **Зөгийн шаваа**	Олон тооны зөгий бүлэг үүсгэн бөөгнөрөх төлөв байдал юм.
34	Colony **Бүл**	Зөгийн нэгдлийг тоолох нэгж . Зөгийн аж ахуйд нэг үүр хайрцганд байгаа зөгийнүүдийг нэг бүл зөгий гэж үздэг.
35	Comb **Сархиаг**	Зургаан талт хэлбэртэй олон тооны ташаалавчнууд хоёр талаас нь ёроолоороо нийлж эгнэн байралсан зүйл бөгөөд зөгийн хувьд үр төлөө бойжуулах, тэжээлээ нөөцлөх зориулалтаар ашигладаг зүйл юм.
36	Comb honey **Сархиагтай бал**	Зөгийн бал хуримтлагдсан сархиагийг хэлбэр гаргаж хэрчиж авсан зүйл. Үүнийг бэлтгэхэд зориулагдсан иж бүрдэл бас байдаг.
37	Creamed honey **Өтгөрүүлсэн бал**	Тодорхой нөхцөлд зориудаар талсжилт үүсгэсэн зөгийн бал юм. Ийм бал нь зарим тохиолдолд хэрэглэхэд хялбар, мөн амтлаг байдаг.

38	Cross-pollination **Солбицон тоос хүртэх**	Нэг овгийн боловч өөр төрөл зүйлийн цэцэг харилцан тоос хүртэх явдал юм. Тариалангийн аж ахуйд үр жимсийг нэмэгдүүлэх зорилгоор зөгийгөөр тоос хүртээлгээдэг.
39	Crystalization **Талсжилт**	Зөгийн бал нь бага температурт талсжих явдал.
D		
40	Dearth **Тэжээлийн хомсдол**	Ерөнхий утгаараа өвөлжилтөөс бусад улиралд цаг агаарын нөхцөл байдлаас (хур тундас, ган) шалтгаалан балт зөгийн тэжээлийн эх үүсвэр болох цэцэгт ургамал ховордох үе.
41	Decoy hive **Бүл тосох үүр хайрцаг**	Сүрэглэсэн бүлийг оруулах зорилготой бэлтгэсэн үүр хайрцаг. Мөн өгөөш үүр хайрцаг (**Bait hive**), сүрэглэл баригч үүр хайрцаг (**Swarm catcher**) гэж нэрлэсэн байдаг.
42	Dividing **Бүл салгах**	Хүчтэй бүлийг 2 болон түүнээс олон хэсэгт хуваахыг хэлнэ. Үржлийн улиралд зөгийн бүлийг зориудаар буюу **artificial swarm** гэх аргаар хувааж буй явдал юм.
43	Division board feeder **Идүүр**	Үүр хайрцган дотор зөгийг тэжээх зорилгоор сахарын уусмалыг дотор нь хийх зориулалт бүхий мод болон хуванцараар хийсэн сав.
44	Drifting bees **Төөрсөн зөгий**	Өөр бүлийн үүр хайрцаганд орсон зөгий.
45	Drone **Эр зөгий**	Эр хүйстэй балт зөгий. Эр зөгий нь үр тогтоогүй өндгөн эсээс бий болдог. Эх зөгий ташаалавчны амсарыг хэмжээд зориудаар гаргасан эсвэл өндгөвчний хөгжил нь саатсан болон ажилчин зөгий асмарч өндөглөх үед эр зөгий бий болно. Эр зөгий нь бүлийн нийт сүргийн 10 орчим хувийг эзэлдэг.
46	Drone laying queen **Эр зөгий төрүүлдэг эх зөгий**	Үр тогтоогүй өндгөн эсээс үүссэн өндөг гаргадаг эх зөгий. Эх зөгий хөгширсөн эсвэл дутуу хээлтэх нь гол шалтгаан болдог.
47	Dwindling **Зөгий цөөрөх**	Зөгийн бүл дэхь ажилчин зөгийний тоо буурах. Тухайлбал хаврын эхэн үед өвөлжсөн зөгий үхэж хорогдож байдаг.
48	Dysentery **Чацга алдах өвчин**	Бие гүйцсэн зөгийн хүнд хэлбэрийн чацга алдах өвчин. Шингэц муутай тэжээл, таагүй чийглэг орчин, нозема өвчний халдвар зэрэг нь энэхүү өвчин үүсэх эх үүсвэр юм.
E		
49	Egg **Өндөг**	Балт зөгийн биеийн хөгжлийн эхний үе шат юм. Өндөг нь бүх төрлийн зөгийн хөгжлийн хувьд эхний гурав хоногт багтдаг.

50	Entrance reducer **Нисгэвчний хаалт**	Зөгийн үүр хайрцагны нисгэвчний зайг тохируулдаг зүйл.
51	European foulbrood **Европ үжил өвчин**	**Melissococcus plutonius** гэх нянгаар үүсгэгддэг зөгийн авгалдайн халдварт өвчин юм. Америк үжил өвчинтэй харьцуулахад авгалдайг эрт үед нь буюу хаалт хийгдэхээс өмнө халдварлаад улмаар үхүүлдэг. Үхсэн авгалдайн сэг зэмийг гогдож үзэхэд утаслаг үүсэхгүй. Хэдийгээр үүсгэгч нь хуяг (спор) үүсгэдэггүй нян боловч халдвар тасардаггүй шинжтэй гэж үздэг. Авгалдайн бусад өвчинтэй төстэй шинж тэмдэг (агааргүйдэх болон тэжээл дутагдаснаас үхэх) үзүүлэх учир онош тогтоохдоо болгоомжтой хандах (нялх авгалдайн хэвийн үхлээс ялган оношлох) шаардлагатай.
52	Extractor **Бал ялгуур**	Зөгийн балыг дүүгүүрдэх буюу төвөөс зугтах хүчээр сархиагнаас ялгахад зориулсан багаж юм. Үйлдвэрлэлийн хэмжээнээс хамаарч ихэнхдээ 1-10 орчим балны жаазны багтаамжтай боловч шаардлагаас хамаарч асар том хэмжээтэй ч байдаг.
53	Extracted honey Ялгасан бал	Зөгийн бал ялгуураар сархиагнаас ялгасан зөгийн бал.
F		
54	Feeders **Идүүр**	Амтат шүүс дутагдалтай зөгийн бүлийг сахарын уусмалаар тэжээх зориулалт бүхий сав. Жаазны хэмжээтэй ижил тул үүр хайрцган дотор зүүж хэрэглэнэ. Мөн үүр хайрцагны тагны дор тавьж хэрэглэдэг идүүр байдаг.
55	Fermenting honey **Исгэсэн зөгийн бал**	Зөгийн балан дахь чийгийн (усны) агууламж өндөр (20%-иас дээш) бол сахар нь задарч исэлдэлт явагдах буюу нүүрсхүчлийн давхар исэл болон алкоголь үүсдэг. Ийнхүү зөгийн бал чийгшил ихтэйгээс болж исдэг байна.
56	Fertilized egg **Үр тогтсон өндөг**	Ерөнхий утгаараа эх зөгийн гаргасан эм хүйстэй зөгий болох өндөг гэсэн үг юм. Ажилчин зөгий бойжих ташаалавчинд өндөглөх үед эх зөгийн хэвлий дэх үрийн хүүдийд нөөцлөгдсөн эр үрийг өндгөн эс болгонд зарцуулж гаргасан өндөг юм.
57	Field bee **Гадна ажлын зөгий**	Гурван долоо хоногоос дээш настай буюу үүрнээсээ гадагш гарч амтат шүүс, цэцгийн тоос, ус, жилий цуглуулах чадвартай болсон ажилчин зөгий. Дотор ажлын зөгий гэдгийн эсрэг утгыг агуулдаг.

58	Follower board **Хашлага самбар**	Зөгийний тоо цөөн, цөөхөн жаазтай тохиолдолд үүр хайрцган доторх зайг шахаж багасгах буюу зөгийтэй хэсгийн эзэлхүүнийг хязгаарлах зориулалт бүхий нимгэн хавтан юм. **Dummy board, Division board** гэж нэрлэж болдог.
59	Food chamber **Тэжээлийн давхар**	Өвөлжих зориулалттай давхар үүр хайрцагны өвөлжих тэжээл бүхий хэсэг
60	Forage **Тэжэээлийн эх үүсвэр**	Байгалийн болон таримал ургамлаас цуглуулсан зөгийн хоол тэжээл. (Амтат шүүс, цэцгийн тоос)
61	Forager **Тэжээгч зөгий**	Үүр хайрцагнаас гарч амтат шүүс, цэцгийн тоос, ус, модны давирхай цуглуулдаг 3 долоо хоногоос дээш настай ажилчин зөгий юм.
62	Foundation **Сэмж**	Зөгийн лаван нимгэн ялтас бөгөөд үүний 2 талд нь ташаалавчнуудын суурь хэсгийн дүрсийг товойлгон гаргасан зүйл. Үүнийг жаазанд бэхлэх ба сархиаг баригдах эхлэл болдог. Албан ёсны нэр нь **Comb foundation**, зарим тохиолдолд **Starter** гэж нэрлэдэг.
63	Frame **Жааз**	Сархиаг бэхлэгдэж буй тэгш өнцөг бүхий модон жааз бөгөөд дээд хөндлөвч, гуя, доод хөндлөвч гэсэн хэсгүүдээс бүрддэг. Жааз нь зөгийн зорчих зайг бий болгох зориулалт агуулж байдаг.
64	Fructose **Фруктоз**	Зөгийн балан дахь үндсэн 2 төрлийн сахарын нэг нь бөгөөд ихэнх төрлийн баланд нэлээдгүй хэмжээгээр (35 ～42%) агуулагддаг. Фруктоз нь амар талсждаггүй. Нөгөө төрлийн сахарыг глюкоз (**glucose**) гэдэг.
G		
65	Glucose **Глюкоз**	Цэцгийн амтат шүүсэнд сахороз ихтэй байдаг. Үүнийг зөгий альфа-глюкооксидаз (α-glucosidase) ферментээр задалж фруктозын хамт бий болгодог.
66	Glucose oxydase **Глюкооксидаз**	Энэ нь зөгийн биед ялгардаг фермент бөгөөд зөгийн балан дахь глюкозыг исэлдүүлэн зөгийн биед глюконы хүчил (**gluconic acid**) болон устөрөгчийн хэт исэл (**hydrogen peroxide**) үүсгэдэг. Энэ задралаас биеийн дотоод үйл ажиллагаанд шаардлагатай энерги үүсдэг.
67	Grafting **Авгалдай зөөвөрлөх**	Ажилчин зөгийн авгалдайг тухайн бойжиж буй ташаалавчнаас эх зөгий бойжуулахаар зохиомлоор бэлтгэсэн өлгийвчинд (аяганд) шилжүүлэх.
68	Grafting tool **Авгалдай зөөвөрлөх зүү**	Эх зөгий гаргах зорилгоор ажилчин зөгий бойжиж буй ташаалавчнаас нялх авгалдайг гаргаж авах болон зохиомлоор бэлтгэсэн өлгийвчинд шилжүүлэхэд зориулагдсан багаж.

69	Granulated honey **Талсжсан зөгийн бал**	Байгалаараа болон зориудаар талсжуулсан зөгийн бал.
70	Guard bee **Хаалгач зөгий**	Гурван долоо хоногийн настай ажилчин зөгийн биед дохиолол фермон, зөгийн хор хамгийн их хэмжээгээр байдаг байна. Ийм зөгий нь нисгэвчний ойролцоо байж өөр үүрний зөгий болон бусад шавж зэргийг үүр хайрцганд орохоос сэргийлж байдаг.
H		
71	Head **Толгой**	Нийлмэл нүд, антенн, ам гэх мэт эрхтнүүдийг агуулсан биеийн урд хэсэг бөгөөд дотор нь шүлсний булчирхай, тархи, бусад хэд хэдэн шүүрлийн булчирхай байдаг.
72	Hive **Үүр хайрцаг (зөгийн гэр)**	Хүн зориудаар бэлтгэсэн зөгий амьдрах үүр юм. Орчин үеийн зөгийчдийн ашиглаж буй үүр хайрцаг нь суурь хэсэг, их бие, таг, жааз гэх мэт хэсгээс бүрдэнэ. Үүр хайрцгийг модны хонгил ашиглаж хийдэг уламжлал байдаг. Үүр хайрцгийг зөгийг тоолох нэгж болгон ашигладаг.
73	Hive bee **Дотор ажлын зөгий**	Ихэнхдээ үүр хайрцган доторх ажлыг хийдэг ажилчин зөгий юм. Талбайн зөгий (**field bee**) гэдэгтэй адил утгатай юм.
74	Hive body **Үүр хайрцагны их бие**	Жаазнуудыг агуулж байдаг хайрцаг
75	Hive inspection **Бүлийн үзлэг**	Үүр хайрцагны тагийг онгойлгоод жаазыг дээш сугалж нөхцөл байдлыг хянах. Орчин үеийн үүр хайрцаг нь зөгийн бүлийн нөхцөл байдлыг нарийвчлан шалгах, тохируулах боломжтойгоор бүтээгдсэн байдаг.
76	Hive stand **Үүр хайрцагны тавиур**	Үүр хайрцгийг газрын чийг, ялзарч муудах, шоргоолжны хөнөөл зэргээс хамгаалж дээр нь байрлуулах тавцан юм.
77	Hive tool **Ховхчуур**	Нэг үзүүр нь хусуурын зориулалттай махир, нөгөө үзүүр нь нимгэлж ирэлсэн хавтгай төмөр багаж юм. Үүр хайрцгийг нээх, жаазнуудыг хөдөлгөх, үүр хайрцагны хэсгүүдэд зөгийн наасан лав, жилий зэргийг хусаж малтах зэрэгт ашигладаг.
78	Hydroxymethylfurfural **Гидрооксиметил фурфурол**	Зөгийн балны олон улсын стандартын нэг үзүүлэлт бөгөөд халаасан болон удаан хадгалсан байдлыг илтгэдэг шалгуур үзүүлэлтээр ашигладаг. Халуун орны зөгийн баланд өндөр хувьтай илэрдэг. HMF гэж товчлон бичдэг.

79	Honey **Зөгийн бал**	Балт зөгий нь цэцгийн амтат шүүсийг цуглуулж боловсруулсан чихэр амтат зүйл юм. Сахарын агууламж 80% -иас дээш байдаг бөгөөд фруктоз, глюкоз нь мальтоза, сахароз, зарим олигосахарид зэргийг агуулж байдаг. Чийгшил нь 20% ба түүнээс бага, мөн найрлаганд нь органик хүчил, эрдэс бодис, витамин, амин хүчил, фермент гэх мэт зүйлүүд багтаж байдаг.
80	Honeydew **Амтат шүүдрийн бал**	Ургамлын эрхтний амтат шүүсээр хооллодог шавж (Hemiptera)-ны ялгадсыг цуглуулж боловсруулсан мөн ургамал, ургамлын амьд хэсгийн шүүрлээс гаралтай зөгийн бал юм. Үүнийг **honeydew honey** гэнэ.
81	Honey flow **Амтат шүүсний үе**	Сайн чанарын балт ургамал их хэмжээгээр цэцэглэж, зөгий хангалттай хэмжээгээр амтат шүүс цуглуулах үе.
82	Honey gate **Балны гаралт тохируулагч**	Бал ялгуурын хананд бэхлэгдсэн ялгарсан бал урсаж гарах хэмжээг тохируулагч (хувиарлагч) хэсэг.
83	Honey house **Зөгийн бал хураах байр**	Зөгийн бал ялгах ажил хийх болон зөгийн аж ахуйн багаж хэрэгсэл хадгалах байр
84	Honey plant **Балт ургамал**	Цэцгийн шүүсэвчнээсээ амтат шүүс ялгаруулдаг ургамал. (Зөгийн балны үйлдвэрлэлд хангалттай хэмжээний амтат шүүс ялгаруулж өгч чаддаг ургамал)
85	Honey stomach **Балны ходоод (Гүеэ)**	Зөгийн улаан хоолойн төгсгөл, буюу хэвлийн урд хэсэгт байралдаг ба амтат шүүс, ус уухад томрох, тэдгээрийг түр хадгалах эрхтэн юм. Мөн **Honey sac**, **Crop** гэж нэрлэх нь бий.
86	Honey supers **Балны давхацуур**	Зөгийн бал хуримтлуулах зориулалттайгаар үүр хайрцган дээр давхарлаж байрлуулдаг ердийнхөөс гүехэн хайрцаг. Мөн дотор нь балны жааз, самбар зэргийг хадгалж болно.
I		
87	Imago **Бие гүйцсэн зөгий**	Ташаалавчны тагийг мэрж эвдэн гарч ирж буй шинэ зөгий. Энэхүү нэр нь насан хүрсэн зөгийг хооронд нь ялгахад ашиглагддаг юм. Хаалтны тагийг мэрж гарч ирсэний дараагаас **Adult bee** гэсэн үгийг ашигладаг.
88	Instrumental insemination **Зохиомол хээлтүүлэг**	Эх зөгий үржүүлэгч болон судлаачид тусгай багаж ашиглан үржлийн эр зөгийн үрийн шингэнийг хээлгүй эх зөгийн үржлийн эрхтэнд тарих арга юм.

89	Invertase **Инвертаз фермент**	Зөгийн балан байдаг фермент бөгөөд сахароз гэх дисахаридыг глюкоз, фруктоз гэх моносахарид болгон задалдаг. **α-glucosidase** нь ийм ферментийн нэг юм
90	Italian bees **Итали зөгий**	Дэлхийд хамгийн түгээмэл тархсан барууны зөгийн үүлдэр юм. **Apis mellifera ligustica** нь барууны зөгийн дэд зүйл бөгөөд дөлгөөн ааштай, бор ба шар алагласан зүстэй, ашиг шим өндөртэй, хулгайч зантай байдаг.
L		
91	Landing-board **Буух тавцан**	Бүл рүүгээ буцан ирж буй ажилчин зөгийг үүр хайрцаг руу ороход нь хялбар болгохоор нисгэвчний өмнө бэхэлсэн тавцан. **Alighting board** гэж нэрлэх нь бий.
92	Larva (pl. -ae) **Авгалдай**	Зөгийн биеийн хөгжлийн хоёр дахь үе шат ба цагаан өнгөтэй, хөлгүй, цохны авгалдайтай төстэй юм. Авгалдайн хөгжлийн үргэлжлэх хугацаа нь эх зөгий, ажилчин зөгий, эр зөгийн хувьд ижилхэн 6 хоног байдаг.
93	Laying workers **Асмарсан ажлын зөгий**	Бүлд эх зөгий байхгүй болсон бөгөөд шинээр эх зөгий гарах боломжгүй үед үр тогтоогүй өндөг төрүүлж буй ажилчин зөгийг хэлнэ. Ийм өндөгнөөс зөвхөн эр зөгий бий болох бөгөөд тус бүл дэвжих боломжгүй байдаг.
M		
94	Mating flight **Үржлийн нислэг**	Үржилд ороогүй эх зөгий үүрнээс гарч хэд хэдэн эр зөгийтэй үржилд орох
95	Mead **Зөгийн балны дарс**	Зөгийн бал нь ус ихтэй бол ямар ч тусгай технологигүйгээр исэж эхэлдэг байна. Үүнийг эрт дээр үеэс хүмүүс ууж ирсэн байна. Зөгийн балны дарс (**Honey wine**) гэж нэрэлдэг.
96	Migratory beekeeping **Нүүдлийн зөгийн аж ахуй**	Бал үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд балт ургамлын гарцыг даган зөгийн суурийг нүүлгэн шилжүүлдэг арга барилтай аж ахуй.

97	Movable frames **Зөөврийн жааз**	Зөгийн бүлд үзлэг хийхэд хялбар байхаар үүр хайрцагны дотор нэг нэгээр нь хөдөлгөж болохуйц жааз бөгөөд түүнд зөгий сархиагаа барьж бэхэлдэг зүйл. Үүний тусламжтайгаар зөгийн зорчих зай (Beespace) зөв болох сархиаг хооронд мөн захын сархиаг хайрцагны хана хоорондын зайг тохируулж болдог.
N		
98	Nasonov gland **Насовын булчирхай**	Ажилчин зөгийн хэвлийн 7-р үенд байрлах үнэр (фермон) ялгаруулах булчирхай. Үүр хайрцагны үүд хэсэгт бүлийнхээ бусад зөгийг дуудахын тулд бөгсөө ондойлгон махийлгаж агаарт үнэрээ цацдаг.
99	Nectar **Амтат шүүс**	Зөгийн балны түүхий эд бөгөөд ургамлын шүүсэвчнээс ялгардаг амтат шингэн юм. Энэ нь сахароз гэх сахарын нэгдэл бөгөөд глюкоз, фруктоз их байх тохиолдол байдаг.
100	Nectary **Шүүсэвч**	Ургамлын амтат шүүс ялгаруулах эрхтэн. Энэ нь ихэвчлэн үр боловсрох орны дор байралдаг боловч цэцгийн гадна шүүсэвч байрлах нь бий.
101	Newspaper method **Сонингоор бүл нийлүүлэх арга**	Хоёр бүл зөгийг нэгтгэхийн тулд өргөжих бүл болон нэмэрлэх бүлийн хооронд сонингоор тусгаарлаж аажмаар нийлүүлэх арга юм. Бүлүүд нийлэх процесс 2-3 хоногт амжилттай болдог.
102	Nosema disease **Нозема өвчин**	Nosema apis гэх эгэл биетнээр үүсгэгддэг ба бие гүйцсэн ажилчин зөгийний хоол боловсруулах замын эмгэг юм. Гол шинж тэмдэг нь чацга алдах бөгөөд үүр хайрцагны гадна тал их хэмжээний баасаар бохирлогдох байдаг. Өвчилсөн зөгийний гэдэсний биелэг байдал үгүй болж шалчийх, өнгөргүй болох ба шинжилгээгээр дээрх эгэл биетэн илэрч байвал нозема өвчин гэж оношилдог.
103	Nucleus hive **Хээлтүүлгийн хайрцаг**	2-5 ширхэг жааз бүхий бага оворын үүр хайрцаг бөгөөд эх зөгий дасгах, хадгалах, хээлтүүлэгт гаргах, бүлэнцэр бий болгох зорилгоор ашигладаг. **Nuc** гэж товчлон бичсэн байдаг.
104	Nurse bees **Асрагч зөгий**	Үүрэн доторх ажиллах зөгийний нэг хэсэг бөгөөд 3-10 хоногийн настай. Авгалдайнуудыг тэжээх нь тэдний гол ажил юм.
O		
105	Observation hive **Ажиглалтын үүр хайрцаг**	Зөгийн үүрний дотор талыг ажиглахын тулд шил гэх мэт нэвт харагдах тунгалаг материалаар хийсэн тусгай үүр хайрцаг. Үүнийг зөгийн бал худалдаалах зэрэг үед худалдан авгчийн анхаарлыг татах, мөн сургалт, судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашигладаг.

106	Out-apiary **Зөгий оторлож буй газар**	Зөгийн суурийг алс бэлчээрт байрлуулж буй газар. **Outyard** гэж хэлэх нь бий.
107	Overstocking **Даац хэтрэх**	Тодорхой нутаг, тодорхой цаг хугацааны байгалийн нөөц нь тэнд байрлуулсан зөгийд хүрэлцэхгүй байх явдал юм. Энэ үед зөгийн балны цугларах хэмжээ багасаж өөр бүлийн балруу зөгий дайрах үзэгдэл ихэсдэг тул зохицуулалт хийх шаардлага гардаг.
P		
108	Package bees **Пакеттай зөгий**	Сархиагтай жаазгүйгээр тор бүхий хайрцганд хийсэн, худалдан борлуулах зориулалттай (эх зөгийтэй, зөгийгүй) бүл юм. Ихэвчлэн 1-2 кг зөгий хийсэн байдаг.
109	Paralysis **Саажих өвчин**	Бие гүйцсэн зөгийний далавч нь хатанхайрч хөдөлгөөнгүй болдог шинж тэмдэг бүхий вируст өвчин бөгөөд хаврын улиралд ихэвчлэн тохиолдох ба түрхэн зуур үргэлжилдэг байна. Хачгийн халдварлалттай шууд хамааралтай тухай судалгааны тайлангуудад бичигдсэн байдаг. Зөгийн нуруу, цээж, хэвлийн үс унаж бие нь хар өнгөтэй болсон харагдана. Нисгэвчээр гарсан зөгий тэр хавьдаа үхсэн байх ба өвчилсөн зөгий их үед хэдэн зуугаараа үхсэн харагддаг. Гадна ажлын зөгий пестицидэд хордож үхэхээс шинж тэмдэгийн хувьд эрс ялгаатай юм.
110	Piping **Эх зөгийн сигнал**	Шинэ эх зөгий торнивчноос гарах үедээ дуугарах чимээ.
112	Play flight **Дасах нислэг**	Залуу зөгий бүлийнхээ байршлыг мэдэхийн тулд үүр хайрцагнийн өмнө болон эргэн тойронд богино хугацаанд нислэг хийхийг хэлнэ. Заримдаа тэднийг хулгайч зөгий мөн сүрэглэлд бэлтгэж байна гэж андуурах тохиолдол байдаг. **Orientation flight** гэж нэрлэх нь бий.
113	Pollen **Тоосонцор**	Ургамлын эр бэлгийн эс бөгөөд үржлийн эрхтний дохиур дээр байрлана. Зөгий үүнийг цуглуулж ууран гэх мэт шим тэжээлийн эх үүсвэрээ болгодог.
114	Pollen basket **Тоосонцорын сагс**	Зөгийн хойд мөчний гадна талд байралдаг, гадна хүрээгээрээ өөдөө ширхэгтэй үснүүд байралсан хонхорхой хэсэг юм. Дунд хэсэгт нэг ширхэг урт үс байдаг. Зөгий энд цэцгийн тоосонцор болон жилийг барьцалдсан хэлбэртэйгээр цуглуулаад авч ашигладаг.
115	Pollen load **Ачаалсан цэцгийн тоосонцор**	Тоосонцорын сагсанд байгаа барьцалдсан цэцгийн тоос. Эрүүл мэндэд тустай тул хүмүүс хүнсний зоиулалтаар хатааж нунтаглан ашигладаг.

116	Pollen substitute **Тоосонцор орлуулагч**	Шар буурцгийн нунтаг, хуурай сүү, пивоны дрожны холимог бөгөөд түүнийг зөгийн бүлийн өсөлтийг дэмжих зорилгоор тэжээл болгон өгдөг.
117	Pollen supplement **Тоосонцорын нэмэлттэй тэжээл**	Зөгийн цуглуулж ирсэн тоосонцорыг урьдчилан аваад бүлийг тоосонцорын хомсдолтой үед нь нэмэлт тэжээл болгон өгөхөөр бэлтгэсэн зүйл.
118	Pollen trap **Тоосонцор цуглуулагч**	Гадна ажлын зөгийнүүдийн тоосонцорын сагсандаа тээж ирсэн тоосонцорыг хүний хэрэгцээнд зориулж зориудаар хураан цуглуулдаг төхөөрөмж юм. Зөгийг нарийхан зайгаар нэвтрэн гарах үед нь тоосонцор мултарч унагаадаг хэд хэдэн арга байдаг.
119	Pollination **Тоос хүртээлт**	Үрт ургамлын цэцгийн тоосны мөхлөгийг нөгөө цэцгийн үр боловсрох орны амсар хүртэл зөөвөрлөж үржлийг нь дэмжих явдал юм.
120	Pollinator **Тоос хүртээгч**	Цэцгийн тоосны мөхлөгийг тоосовчноос нөгөө цэцгийн үр боловсрох орны амсар хүртэл зөвөөрлөгч. Зөгий, ялаа, цох хорхой гэх мэт
121	Prime swarm **Анхны сүрэглэл**	Үндсэн бүлээс анх тасран сүрэглэсэн бүл бөгөөд эх зөгий нь дараагийн эх зөгийд бүлээ даатгаад явах
122	Proboscis **Пробоск**	Цэцгийн амтат шүүсийг сорох зориулалттай зөгийн амны хөндийн сунадаг хэсэг.
123	Propolis **Жилий**	Зөгий нь ургамлын давирхайг түүхий эд болгон ашигласан үүр хайрцагныхаа онгорхой цоорхойг нөхөн залгаас хэсгүүдийг бэхэлдэг. Жилий нь нянгийн эсрэг үйлчилгээтэй тул эрүүл мэндийн бүтээгдэхүүн болгон ашиглагддаг юм. Гарал үүслийн хувьд улиас гол ургамал боловч тухайн нутаг орны ургамлаас шалтгаалж өөр өөр байдаг. Жилийг өөрөөр зөгийн цавуу гэж нэрлэх нь бий.
124	Pupa (pl. -AE) **Хүүхэлдэй**	Зөгийн биеийн хөгжлийн гурав дахь үе шат юм. Үүний өмнө өндөг, авгалдайн үе шат байх ба бие гүйцсэн зөгий болохын өмнөх үе шат юм. Хүүхэлдэйн хөгжлийн үргэлжлэх хугацаа нь каст бүрт өөр байх ба эх зөгийд 7 хоног, эр зөгийд 14 хоног, ажилчин зөгийд 12 хоног байдаг.
Q		
125	Queen **Эх зөгий (Хатанз)**	Үржих чадвар бүхий эм хүйстэй зөгий. Эр зөгийтэй эвцэлдсэнээр бүлийн дотор цорын ганц өндөглөх чадвар бүхий зөгий болдог. Зөгийн бүлд эх зөгий ганцхан байдаг.
126	Queen cage **Эх зөгийг түр хадгалах тор**	Эх зөгийг тээвэрлэх, өөр бүлд шилжүүлэхийн тулд түр агуулж байх жижигхэн торон сав бөгөөд үүнд эх зөгийг хэд хэдэн ажилчин зөгийн хамт хийдэг.

127	Queen cell **Торнивч**	Эх зөгий бойжих зориулалт бүхий тусгай (урт) ташаалавч бөгөөд доошоо харсан хонх хэлбэртэй байдаг.
128	Queen clipping **Эх зөгийн далавч хяргах**	Зөгийн бүлийг сүрэглэхээс сэргийлэх мөн сүрэглэл эхэлсэнч эх зөгийг нисгэхгүй байлгахын тулд түүний өрөөсөн далавчийг хяргах
129	Queen cup **Өлгийвч**	Зөгий лав эсвэл хуванцараар хийсэн жижиг аяга хэлбэртэй сав бөгөөд үүнийг бойжуулгын жаазны хөндлөвч дээр доош харуулан бэхлэнэ. Үүнд өндөг эсвэл залуу авгалдайг шилжүүлж зөгийн бүлд оруулж тавина. Хэрэв бүл хүлээж авсан бол сүүнцэр хуримтлагдаж, лаваар өлгийвчийг томосгож барина.
130	Queen excluder **Эх зөгий тусгаарлах тор**	Үүр хайрцган доторх тодорхой хэсэг рүү эх зөгий болон эр зөгийг оруулахгүйгээр хязгаарласан төхөөрөмж (тор) юм. Зөгийу бүл бүхий үүр хайрцагийг давхарлах тохиолдолд доод хэсэг буюу эх зөгийг өндөглөж байгаа давхраас дээд хэсэг буюу бал хурааж буй хэсэгрүү оруулахгүй байх зорилгоор ашигладаг. Энэ нь хуванцар эсвэл төмрөөр хийгдсэн ба зөвхөн ажилчин зөгий нэвтрэх зайтай тор юм.
131	Queen rearing **Эх зөгий бойжуулах**	Сайн удмыг хадгалах болон үржлийн зорилгоор зохиомол өлгийвчинд эх зөгий бойжуулах
132	Queenless colony **Эх зөгийгүй бүл**	Эх зөгий байхгүй бүл.
133	Queenright colony **Эх зөгийтэй бүл**	Үр тогтсон өндөг төрүүлэх чадвар бүхий эх зөгийтэй бүл.
134	Queen substance **Эх зөгийн бодис (үнэр)**	Эх зөгийн эрүүний том булчирхайнаас ялгардаг фермон (үнэр) юм. Ажлын зөгийнүүд биеийг нь долоож авсан уг үнэрийг амнаас аманд дамжуулах байдлаар бие биедээ, улмаар бүлийн бүх зөгийнд эх зөгий байгааг мэдэгдэнэ.
R		
135	Requeen **Эх зөгийг солих**	Зөгийн бүлээс хуучин эхийг нь аваад шинэ эх зөгийтэй болгох
136	Rendering wax **Лав бэлтгэх**	Сархиагтай сэмж, балны хаалт, илүүдэс зэргийг хайлган шүүж бохирдлоос салгах байдлаар зөгийн лав бэлтгэх
137	Robbing **Хулгайч зөгий**	Гадна ажлын зөгий өөр бүлийн гэрт нэвтэрч амтат шүүс мөн цэцгийн тоосормог хулгайлдаг. Үүнийг бусад бүлд өвчний халдвар тархах шалтгаануудын нэг гэж үздэг.

138	Royal jelly **Сүүнцэр**	Залуу асрагч зөгийнүүд тоосормог болон бал идсэнээр тэдний залгиурын булчирхай мөн эрүүний том булчирхайны шүүрлээс бий болсон сүүн өнгөтэй, тэжээллэг чанар өндөртэй зүйл юм. Өлгийвч доторхи авгалдай үүгээр тэжээгдэж эх зөгий болон бойждог.
S		
138	Sacbrood **Үрвэлдэй шалхайх өвчин**	Вирусээр халдварлагдсан авгалдай нь хүүхэлдэй болох хугацаандаа хүүдий хэлбэртэй болж толгойн хэсэгт нь ус хуримтлагдсан байдалтай болж үхдэг өвчин юм. Зүүн өмнөд азиас өмнөд ази хүртэл 1980-аад оныг үед маш олон тооны *Apis cerana* зүйлийн зөгий уг вирусээр халдварлан их хэмжээгээр үрэгдсэн (зөгий сүргээрээ устсан) байдаг. Өнөө үед *Apis cerana* зүйлийн зөгийн сүрэгт голчлон халдварладаг өвчин бөгөөд *Apis mellifera* зүйлийн зөгийний хувьд ноцтой жишээ тэмдэглэгдээгүй байна.
139	Scout bees **Хайгуулч зөгий**	Тусгай нэг газрыг зорьж нислэг хийдэггүй тоосонцор, амтат шүүс, жилий, ус эсвэл сүрэглэлийн шинэ үүр хайх зэрэг зорилготойгоор нисдэг үүрний гадаах ажлын зөгий юм.
140	Sealed brood **Битүүмжлэгдсэн үрвэлдэй**	Хүүхэлдэй болж яваа авгалдайн ташаалавч хаалтай байхыг ингэж хэлдэг. **Capped brood** ч гэж нэрлэдэг байна.
141	Self-pollination **Өөртөө тоос хүртэх**	Тухайн нэг ургамлын биед тоос хүртэх процесс явагдахыг хэлнэ.
142	Skep **Сүрлэн үүр**	Сүрлээр сүлжиж хийсэн бөөрөнхий хэлбэртэй Европын уламжлалт зөгийний үүр.
143	Small hive beetle **Үүр хайрцгийн жижиг цох**	Жижиг цох хорхой (Aethina tumida) юм. Түүний авгалдай зөгийн сархиагийг идэж гэмтээдэг. Өмнөд Африкаас дэлхий дахинд маш хурдацтай тархсан. SHB гэж товчилж бичдэг.
144	Smoker **Утуур**	Зөгийн бүлд үзлэг хийх үед зөгийн сүргийг тайвшруулах зорилгоор ашигладаг багаж. Олс, холтос, цаас, аргал зэргийг дотор нь ноцоож хэт халуун биш утаагаар зөгийг утдаг.
145	Solar wax melter / extractor **Нарны гэрлээр лав хайлуулж ялгах багаж**	Сархиаг, балны хаалтыг хайлуулж лав хуримтлуулж авдаг багаж. Тагны шилээр нэвт тусах нарны гэрлийг ашиглах учраас хэт их халахгүй гал гарах аюулгүй байгалийн эрчим хүчийг ашиглаж буй явдал юм.
146	Spermatheca **Үрийн хүүдий**	Эх зөгийн хэвлийд байрлах ба эр бэлгийн эсийг хадгалдаг эрхтэн.

147	Sting **Хатгуур**	Ажилчин болон эх зөгийд аль алинд нь байдаг хатгах зэвсэг юм. Ажилчин зөгийн хатгуур илүү том ба дайсан этгээдийг хатгасан тохиолдолд хатгуур арьсанд шигдэж үлдээд хороо шахсаар байдаг.
148	Sucrose **Сахароз**	Цэцгийн амтат шүүсэнд агуулагдах хамгийн түгээмэл сахар (дисахарид) бөгөөд зөгийн бал боловсруулах явцад ялгаруулах ферментийн нөлөөгөөр глюкоз, фруктоз болон задардаг.
149	Sugar syrup **Сахарын уусмал**	Зөгийн өвөлжих тэжээл мөн цэцгийн шүүс ховордсон тохиолдолд өгдөг сахарын уусмал юм. Ер нь бол сахарозыг бүлээн усанд уусгаж бэлтгэсэн чихэрлэг амттай уусмал юм.
150	Supersedure **Эх зөгий шинэчлэгдэх**	Хуучин эх зөгий шинээр төрсөн өөрийн охин болох шинэ эх зөгийд халаагаа өгч байгаа буюу байгалиараа эх зөгий шинэчлэгдэх үйл явц. (Зөгийн бүл салгах хамаарахгүй)
151	Surplus honey **Нөөцөлсөн зөгийн бал**	Зөгийн бүл удаан хугацааны туршид оршиход шаардлагатай их хэмжээний зөгийн бал. Их авцаас ялгаатай ба зөгийчин боломжтой үеийг тооцож байгаад түүнийг хурааж авдаг.
152	Swarm **Сүрэглэл**	Зөгий үржихийн тулд хуучин эх зөгий бүхий хэсэг бүлэг зөгий үндсэн бүлээс тасран амьдрах шинэ газар хайхаар явах. Мөн үүр хайрцагнаас гадна орчинд шилжиж буй зөгийн бүл гэж ойлгож болно
153	Swarming **Сүрэглэлт**	Зөгийн бүл байгалийн нөхцөлд шилжиж буй үйл явц юм.
T		
154	Tested queen **Сонгогдсон эх зөгий**	Ижил удмын эр зөгийтэй үржилд орж сайн чанарын үр төл гаргаж буй улмаар сайн бүл бий болгох магадлалтай эх зөгий.
155	Thermoregulation **Дулаан зохицуулалт**	Зөгийн бүл жилийн турш үүрнийхээ температурыг 34 ± 1 хэмд байлгадаг. Энэ онцлогийг дулаан зохицуулалт гэж хэлнэ.
156	Thorax **Цээж**	Зөгийн биений хоёр дахь хэсэг. Дотоод бүтцийн хувьд зөгий далавчаа хөдөлгөхөд шаардлагатай нислэгийн булчингийн чухал хэсэг бөгөөд энэхүү булчингийн нөлөөгөөр дулаан ялгаруулдаг. Гадна хэсэгт нь далавч болон хөл байралдаг.
157	Top bar **Зөөврийн жаазны дээд хөндлөвч**	Зөөврийн жаазны дээд хөнлөвч юм .Мөн Кени улсад жаазгүй буюу зөвхөн дээд хөндлөвчтэй үүр хайрцаг байдаг.

158	Tropilaelaps clareae	Гадна шимэгч цус сорогч хачиг бөгөөд Зүүн Өмнөд Азиас гаралтай, Varroa destructor -аас ч илүү хор хохирол ихтэй гэгддэг. Бага температурт тэсвэргүй, зөгийн үрвэлдэйгүйгээр амьдрах нөхцөлгүй болдог учраас хатуу ширүүн уур амьсгалтай өвлийн улиралд (Эх зөгийн өндөглөлт өвлийн улиралд 1 сар орчим зогсдог) халдварлах боломжгүй гэж үздэг.
U		
159	Uncapping knife **Хаалтны хутга**	Жаазнаас бал ялгахын тулд балны хаалтыг зүсэж авдаг багаж юм. Лавыг илүү хялбар зүсэхийн цахилгаан болон уураар халдаг болгосон байдаг . Мөн сам хэлбэрийн хаалт авагч байдаг ба түүнийг **uncapping fork** гэж нэрлэдэг.
160	Uniting **Бүл нийлүүлэх**	Хоёр ба түүнээс дээш зөгийн бүлийг нийлүүлж нэг хүчтэй бүл бий болгохыг хэлнэ.
161	Unsealed brood **Хаалтгүй үрвэлдэй**	Ажлын зөгийн ажиллагаанаас шалтгаалан хараахан хаагдаагүй үрвэлдэй (авгалдай болон хүүхэлдэй)
V		
162	Varroa destructor	Варроа хачгийн халдварыг үүсгэгч гадна шимэгч хачиг юм. Өмнө нь V. jacobsoni гэдэг байсан. Зөгийн Varroa destructor -ийн халдвараас үүдэн далавч нь дутуу хөгжих (далавч нь агшсан, мөч нь дутуу хөгжилтэй) эмгэг бий болно. Шимэгчлэх үед бусад бактери, вируст халдварыг тараах зэргээр зөгийн бүлд маш муу нөлөөтэй. Сөрөг нөлөө нь хаврын улиралд төдийлөн ажиглагдахгүй ч зун, намар тод илэрдэг буюу ажлын зөгийн үрвэлдэйг шимэгчлэн огцом нэмэгддэг байна. Ихэнх тохиолдолд халдвар даамжирч ажлын зөгий нисч чадахгүй болсноор зөгийн бүлийн бүтэц эвдрэн зөгийн аж ахуй маш их хэмжээний хор хохирол амсдаг.
163	Varroosis **Варроа хачгийн халдвар**	Зөгийн Варроа хачигнаас үүдэлтэй шимэгчтэх өвчин юм. Ихэнхдээ зөгийн биед Варроа хачиг харагдах, ажлын зөгийн далавч дутуу хөгжиж далавч нь агшиж нисч чадахгүй болох үзэгдэл ажиглагдана. Халдвар ихэссэн үед ажлын зөгий үрвэлдэйн шатандаа үхэж болно. Вирусийн халдвар хамт явагдах тохиолдол байдаг. Энэхүү хачгийн халдварлалт өндөр тохиолдолд зөгийн бүлийн бүтэц маш эрчимтэй алдагдана.

164	Venom allergy **Зөгийн хорны харшил**	Зөгийнд хатгуулсан амьд биет нь хариу урвал үзүүлэх бөгөөд их бага хэмжээгээр улайж хавдах, загатнах, заримдаа үхэлд хүргэх анафилаксийн шок зэрэг янз бүрийн хариу урвал илэрч болно. Эхний удаад хатгуулахад хэвийн бус хариу урвал илэрсэн тохиолдолд дахин зөгийтэй ойртолгүйгээр эмчээс зөвлөгөө авах хэрэгтэй.
165	Venom gland **Хорны булчирхай**	Эм зөгийн (ажлын зөгий болон эх зөгий) хатгах үед ялгаруулдаг хорт бодисыг бий болгодог эрхтэн.
166	Venom hypersensitivity **Зөгийн хоронд хэт мэдрэг байдал**	Зөгийд хатгуулаад анафилаксийн шок үүсэж болзошгүй нөхцөл байдлыг хэлнэ. Хэт мэдрэг хүмүүс дулааны улиралд гадагш гарахдаа яаралтай тусламжийн хэрэгсэл авч явах хэрэгтэй. Мөн үүнийг Poison gland гэж нэрлэдэг.
167	Venom sac **Хорны хүүдий**	Хорны булчирхайгаас үүссэн шингэнийг хадгалдаг уут хэлбэрийн эрхтэн. Хатгах үед хатгуурын хамт хэвлийн хэсгээс гадагшилдаг. Заримдаа Poison sac гэж нэрлэдэг.
168	Virgin queen **Үржилд ороогүй эх зөгий**	Торнивчноос гарсан боловч хараахан эр зөгийтэй эвцэлдэж үр тогтоогүй эх зөгий юм. Mated Queen-ийн эсрэг үг.
W		
169	Waggle dance **Бөгсөө чичирхийлэх бүжиг**	Гадна ажлын зөгий бусаддаа хоол тэжээлийн байрлалыг мэдэгдэхийн тулд үүрний дотор, нисгэвчний ойролцоо бүжиглэх бөгөөд энэ нь нислэгийн зай болон чиглэлийн мэдээллийг агуулдаг.
170	Winter cluster **Зөгийн шаваа**	Гадна орчны температур буурах үед бие биенээ дулаацуулахын тулд зөгийнүүд бөөгнөрч нягтрах байдал.
171	Wax glands **Лавны булчирхай**	Ажилчин зөгийн хэвлий буюу биеийн 4-р үед байрлах лав ялгаруулдаг булчирхай юм.
172	Wax moth **Лавны эрвээхэй**	Galleria mellonella -ийн авгалдайн хөнөөл юм. Жаазанд торгон утас болон ялгадсаараа биеэ хамгаалахын тулд хонгил барьж нүүдэллэн сархиагыг идэж сүйтгэдэг. Мөн хадгалж байгаа жаазтай сархиагыг сүйтгэнэ. Цэцгийн тоосонцорын үлдэгдэлтэй, мөн зөгий дөнгөж бойжиж гарсан ташаалавчинд үүрлэх нь элбэг байдаг. Зуны халуунд идэвхитэй үрждэг.
173	Worker **Ажилчин зөгий**	Өндөглөх эрхтэн хөгжөөгүй эм хүйсийн зөгий юм. Зөйн бүлд шаардлагатай бүхий л ажлыг нас насандаа тохируулан хувиартайгаар хийж гүйцэтгэдэг. Өндгөвчтэй боловч үр тогттож өндөглөдөггүй.

174	Worker cell **Ажилчин зөгий бойжих ташаалавч**	Зөгийн үүрэн дотор хамгийн элбэг ташаалавч бөгөөд энд эх зөгий өндөглөж түүнийг ажлын зөгий өсгөж бойжуулдаг. Зөгийн бал болон цэцгийн тоос нөөцөлхөд мөн ашиглана.
175	Wax scale **Лавны мөхлөг**	Ажилчин зөгийн лавны булчирхайнаас ялгаран гарч агаарт царцсан лавны ширхэг. Зөгий үүнийг үмхэж шүлстэйгээ хольж улмаар сархиаг болон ташаалавчны хаалтыг хийдэг.

Ашигласан материал

Б.Занданхүү. 2021. Газар тариалан эрхлэхэд зөгийн тоос хүртээлтийн ач холбогдол. “Монгол агрономч сэтгүүл” № 9. Монголын агрономчдын холбоо

Г. Очирбат. 2019. Монгол орны балт ургамлын нөөц (Дөрөвдүгээр хэвлэл)

Д.Болдбаатар. 2020. “Зөгийн Варроа хачиг,тэмцэх арга хэмжээ” илтгэл

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. https://legalinfo.mn/mn

Зөгийн аж ахуйг дэмжих, үр ашгийг нэмэгдүүлэх төсөл. 2018. Зөгийн эрүүл мэнд, ариун цэвэр, эрүүл ахуйн бүртгэл

Зөгийн аж ахуйг дэмжих, үр ашгийг нэмэгдүүлэх төсөл. 2018. Зөгийн эрүүл мэнд, ариун цэвэр, эрүүл ахуйн бүртгэлийн хяналтын дэвтэр

М. Сасаки. Монголын зөгийчдийн нийгэмлэг. 2015. “Зөгий Цэцэг Жимс” сэтгүүл, № 3

М. Сасаки. Монголын зөгийчдийн нийгэмлэг. 2016. “Зөгий Цэцэг Жимс” сэтгүүл, № 1

М.Сасаки, Г.Удвал, Х.Хошиба, Н.Тогтохбаяр. 2018. Сэлэнгийн бүс нутгийн балт болон тоост ургамал. JAICAF

Мал эмнэлгийн ерөнхий газар. 2019. Мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар зөвлөмжийн эмхэтгэл

Мал эмнэлгийн ерөнхий газар. 2020. Зөгийн аж ахуйд мал эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуйн шаардлагыг мөрдөх нийтлэг заавар

Монгол улсын стандарт. 2011. Зөгийн бал шинжлэх арга (MNS 6293 : 2011)

Монгол улсын стандарт. 2016. Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага (MNS 6648 : 2016)

Монгол улсын стандарт. 2019. Зөгийн бал. Техникийн ерөнхий шаардлага (MNS 6294 : 2019)

Монгол улсын стандарт. 2020. Зөгийн аж ахуйн нэр томьёо, тодорхойлолт (MNS 6827 : 2020)

Монгол улсын стандарт. 2020. Зөгийн гэр. Техникийн шаардлага (MNS 6829 : 2020)

Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн Салбарын Нэмүү Өртгийн Сүлжээний Мастер Төлөвлөгөө Боловсруулах Төсөл (MONMAP-AVC). 2021. Зөгийн балны зах зээлийн судалгаа

Н.Тогтохбаяр. 2016. Зөгий судлал

НХХЯ, ХХААХҮЯ. 2020. Зөгийн аж ахуйд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй дүрэм

BeeDep-MONGOL 2 төсөл. 2020. Зөгийн аж ахуйн гарын авлага (Урьдчилсан хэвлэл)

BeeDep-MONGOL 2 төсөл. 2021. Зөгийн аж ахуйн бизнес менежментийн гарын авлага (Урьдчилсан хэвлэл)

FAO. 2020. Good beekeeping practices, Practical manual on how to identify and control the main diseases of the honeybee (Apis mellifera)

FAO. FAOSTAT. https://www.fao.org/faostat

JAICAF. 2009. 開発途上国での養蜂振興と実務 —アフリカを事例として—
JAICAF. 2014. モンゴルにおける養蜂振興と環境保全 事業報告書
JAICAF. 2016. Япон улсад зохион байгуулсан сургалт дадлагын материал
JAICAF. 2019. Япон улсад зохион байгуулсан сургалт дадлагын материал
JAICAF. 2020. 平成31年度 養蜂女性の経営参加促進のための研修事業 報告書

国際実務マーケティング協会. 2018. ベーシックマーケティング・ビジネスハンドブック. MHJ出版
国際実務マーケティング協会. 2018. アドバンスマーケティング・ビジネスハンドブック. MHJ出版
日本養蜂協会. 2015. 養蜂における衛生管理
日本養蜂協会. ポリネーション用ミツバチの管理マニュアル. https://www.beekeeping.or.jp/farmer/pollinating-manual
原田康. 2012. 農業・農村開発のための農産物流通ハンドブック. JAICAF
干場英弘. 2020. 蜜量倍増 ミツバチの飼い方 これで作れる「額面蜂児」. 一般社団法人農山漁村文化協会
渡辺孝. 2003. ハチミツの百科 新装版. 真珠書院

Тэмдэглэл

ЗӨГИЙН АЖ АХУЙН НЭГДСЭН ГАРЫН АВЛАГА

2022年10月発行
発行: 公益社団法人 国際農林業協働協会 (JAICAF)
〒107-0052 東京都港区赤坂8-10-39　赤坂KSAビル
TEL: 03-5772-7880
FAX: 03-5772-7680
URL: https://www.jaicaf.or.jp

ISBN: 978-4-908563-90-4 print
978-4-908563-91-1 pdf

本書は、JICA草の根技術協力事業「モンゴル国 地方での生計維持を目指した養蜂振興プロジェクト」において作成された「養蜂の手引書」です。